



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/790

Номгон

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн  
бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг  
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "в", 29.1.6 "а" 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2021 оны 385 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгаж байгаатай холбогдуулан иргэд, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймгийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 00:00 цагаас 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 24:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасугай.

2. Дээрх хугацаанд холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ж.Алтангэрэл), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Онцгой комиссын Төв штабын дарга (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН